

Татварын үүрэг, хэрэгжилтийн судалгаа

Tax Functions, Study of Implementation

Н. Тунгалаг¹, Б. Лхагважав², Л. Оюунцэцэг³

Хураангуй

Татвар нь соёлт нийгэмд амьдрах боломжийн төлөө бидний төлж буй төлбөр юм (Оливер У.Холмс, 1809-1894). Өнөөгийн нийгэмд татвар төрийн зүгээс түүгээр дамжуулан зах зээлийн эдийн засагт нөлөөлөх санхүүгийн хөшүүрэг болж өгнө. Аль ч нийгэмд татварын эдийн засгийн мөн чанар нь түүний гүйцэтгэх үүргийн дагуу илэрдэг. Бид энэхүү ажилд Монгол улсын татварын тогтолцоо үндсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг судлан дүгнэлт өгөхийг зорив.

Түлхүүр үгс: татвар, татварын тогтолцоо, татварын үүрэг, үүргийн биелэлт

Abstract

Tax is the payment we pay for living in the cultural society (Oliver U. Holmes, 1809-1894). In today's society, taxes can be a financial incentive for the state to influence the market economy. In any society, the economic nature of the taxes is appearing in accordance with its functions. In this work we aim to explore how the tax system of Mongolia fulfills its primary obligations.

Keywords: tax, tax system, tax function, fulfillment of tax obligations

¹ МУИС-ийн Бизнесийн сургууль, НББ-ийн тэнхимийн профессор, доктор
E-mail: tungalag88@yahoo.com

² МҮХАҮТанхимын ерөнхийлөгч
E-mail: ljav@yahoo.com

³ МУИС-ийн Бизнесийн сургууль, НББ-ийн тэнхимийн ахлах багш, доктор
E-mail: oyuntsetseg_l@yahoo.com

Удиртгал

Эдийн засгийн ухааны хүрээнд татварын гүйцэтгэх үүрэг хэд байхыг тогтоосон нэгдмэл ойлголт өнөөг хүртэл байхгүй байна. Ихэнх номлолуудад татварын үндсэн хоёр үүргийг тодорхойлсон байдаг бол заримд нь таван үүрэг бий гэж үзсэн тохиолдлууд байна (Хүснэгт 1).

Санхүүгийн үүрэг: Улсын мөнгөн сан хөмрөгийг бүрдүүлэх ба үүнийгээ байгууллага, хувь хүмүүсийн орлогын нэг хэсгийг хураан авах замаар гүйцэтгэнэ. Ингэснээрээ төр улсад өөрийн үүрэгт ажлыг гүйцэлдүүлэх материаллаг нөхцлийг нь бүрдүүлж улмаар батлан хамгаалах, хууль сахиулах, нийгмийн болоод байгаль орчны зэрэг асуудлуудаа шийдвэрлэх санхүүгийн гол эх үүсвэр нь болж өгдөг.

Зохицуулалтын үүрэг: Татварын механизмаар дамжуулан хөрөнгө үйлдвэрлэлийн нэг салбараас нөгөө салбарт шилжих үйл ажиллагааг зохицуулдаг.

Хяналтын үүрэг: Аж ахуйн үйл ажиллагааны үр ашигт байдлыг шалгах, улсын эдийн засгийн байдлын үр өгөөжит байдлыг хянах үед тодрон гарна. Зах зээлийн эдийн засгийн өрсөлдөөний нөхцөлд татвар нь санхүү, аж ахуйн үйл ажиллагааны үр ашигт байдлыг хараат бус

байдлаар хянах хамгийн чухал хэрэгслийн нэг болдог.

Нийгмийн үүрэг: Энэ үүрэг нь татварын эдийн засгийн онцгой мөн чанарыг илтгэх бөгөөд түүнийг төвлөрсөн, фискаль хэлбэр бүхий түгээн хуваарилах харилцааны хэрэгсэл мөн гэдгийг харуулна. Энэхүү функц нь угтаа дараахи зүйлд чиглэнэ: татварын тусламжтайгаар төсөв ба хуулиар баталсан төсвийн бус сангуудаар дамжуулж улсын зүгээс санхүүгийн эх үүсвэрүүдийг үйлдвэрлэлийн салбараас нийгмийн салбар руу дахин хуваарилалт хийж шилжүүлэх ба нийт улсын шинж чанар бүхий салбар дундын томоохон зорилгот хөтөлбөрийг санхүүжүүлнэ.

Дахин хуваарилалтын үүрэг: Татварын тусламжтайгаар төсөв ба хуулиар баталсан төсвийн бус сангуудаар дамжуулж улсын зүгээс санхүүгийн эх үүсвэрүүдийг үйлдвэрлэлийн салбараас нийгмийн салбар руу дахин хуваарилалт хийж шилжүүлэх ба төрийн шинж чанар бүхий салбар дундын томоохон зорилтот хөтөлбөрийг санхүүжүүлнэ

Урамшууллын үүрэг: Эдийн засгийн аль нэг үзэгдлийг хөгжүүлж дэмжихэд чиглэх бөгөөд урамшуулал олгох ба төлбөрөөс чөлөөлөх тогтолцоогоор дамжин хэрэгждэг. Үүний эсрэг үл урамшууллын тогтолцоо байж болно.

Хүснэгт 1. Татварын үүрэг

Татварын үүрэг	Санхүүгийн	Зохицуулалтын	Хяналтын	Нийгмийн	Дахин хуваарилалтын	Урамшууллын	Идэвхжүүлэлтийн	Эдийн засгийн
2*	+	+						
2**	+							+
4***	+		+		+		+	
4****	+	+	+	+				
5*****	+	+	+	+		+		

Тайлбар: * - Попова нар (2017); ** - Polinsky нар (2007), Понемасов (2014); *** - Понемасов (2014), Овчинников нар (2012); **** - Karlow (2010). Эх сурвалж: Судлаачдын зэрэгцүүлэлт

Идэвхижүүлэлтийн үүрэг: Энэ нь урамшууллын болон үл урамшууллын тогтолцоотой ойролцоо зорилгоор хэрэгждэг. Төр зарим салбарын үйл ажиллагааг дэмжих заримыг нь хумих бодлого баримтлахад татварын идэвхижүүлэх болон үл идэвхижүүлэх үүрэгтэй нь хамтарч гүйцэтгэнэ.

Эдийн засгийн үүрэг: Татвараар улсын төсөв бүрдүүлж шаардлагатай салбар, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүжилтийн эх үүсвэрээр хангана.

Сүүлийн үеийн судлаачид дээрх хүснэгт дэх татварын эдийн засгийн болон дахин хуваарилалтын үүргүүдийг санхүүгийн үүрэгт нь, урамшууллын болон идэвхижүүлэлтийн үүргүүдийг зохицуулалтын үүрэгт нь хамруулан авч үзэх болжээ (Попова нар, 2017;

Polinsky нар, 2007; Понемасов, 2014; Овчинников нар, 2012). Иймд бид Монгол улсын татварын тогтолцооны үүргүүдийг санхүүгийн, зохицуулалтын, нийгмийн болон хяналтын гэж авч үзэн мөрдөгдөж байгаа татварын эрхзүйн хүрээнд эдгээр үүргүүдээ хэрхэн биелүүлж байгаад судалгаа хийв.

1. Санхүүгийн буюу төсвийн үүрэг нь аливаа татварын тогтолцооны үндсэн үүрэг мөн. Тэрээр аль ч улсын ямар ч татварын тогтолцооны татвар тус бүрд анхдагч шинж нь болж явдаг. Энэ бол зүйн хэрэг юм. Учир нь, төсвийн болон төсвийн бус сангуудад хөрөнгө хуримтлуулж, засгийн газрын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зориулалттай. Энэхүү хөрөнгийг төрийн нийгмийн үйлчилгээ, ахуйн хэрэгцээ, гадаад харилцаа, аюулгүй байдал, захиргаа, удирдлагын зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

Хүснэгт 2. Монгол улсын Төсвийн орлогын бүтэц (хувиар)

Орлого	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Дундаж
Урсгал орлого	98.7	99.1	98.9	98.6	99.7	99.3	99.9	98.1	98.5	98.8	98.9
Үүнээс: татварын орлого	81.0	87.9	82.2	87.3	87.1	86.6	85.5	85.3	86.1	86.3	85.5
Хөрөнгийн орлого	0.1	0.2	0.1	0.18	0.28	0.21	0.06	0.03	0.9	-	0.21
Гадаад тусламжийн орлого	1.2	0.7	1.0	1.2	0.0	0.5	-	1.9	0.6	1.2	0.8
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Эх сурвалж: 1212.мн

Хүснэгт 3. Гол нэр төрлийн татварын орлого (тэрбум төгрөгөөр)

Нэр төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
ААНОАТ	205.4	390.9	545.6	524.3	660.2	621.2	698.8	510.6
НӨАТ	405.2	630.5	1,175.4	1,359.0	1,511.6	1,466.3	1,037.1	1,339.5
ОАТ	166.7	268.5	294.0	312.4	449.4	454.4	592.3	626.9
ХХОАТ	128.2	160.9	232.3	347.0	449.0	477.1	474.1	509.8
Өмчийн татвар	11.2	13.8	17.2	21.9	44.0	50.0	86.5	104.6
НД	263.6	331.3	473.4	650.2	874.2	971.4	1,038.8	1,175.9
Бусад	200.9	309.5	571.9	665.6	742.7	868.4	877.0	586.0
Нийт	1,381.2	2,105.5	3,309.7	3,880.4	4,731.2	4,908.8	4,804.7	4,853.4
Төсвийн зарлага	2,336.6	3,080.7	4,997.0	5,993.8	6,164.7	7,031.4	7,136.9	9,519.9

Эх сурвалж: 1212.мн

Хүснэгт 2-оос харахад сүүлийн 10 жилийн дунджаар төсвийн орлогын 98.9 хувийг урсгал орлого, урсгал орлогын 85.5 хувийг татварын орлогоор бүрдүүлсэн нь татвар санхүүгийн буюу төсвийн үүргээ голлон биелүүлж ирсэнийг харуулж байна.

Хүснэгт 3-т улсын төсвийн бүрдүүлэлтэд голлох үүрэг гүйцэтгэж буй татварын орлогын хэмжээ, сүүлийн 10 жилийн төлөв байдлыг авч үзсэн бөгөөд улс төр эдийн засгийн нөхцөл байдал, татварын бодлогын өөрчлөлтийн нөлөөгөөр нэр төрөл тус бүрээр хэлбэлзэлтэй байгаа боловч жил тус бүрийн татварын орлого тасралтгүй өссөөр байгаа статистик харагдаж байна. Гэхдээ жил тус бүрийн төсвийн зарлагын өсөлтийг гүйцээгүй байгаагаас засгийн газрын хөтөлбөрүүдийн санхүүжилтэнд татварын орлогоос гадна зээл тусламжийн эх үүсвэр, төсвийн алдагдал нэмэгдсээр байна. 2007 онд татварын шинэчлэл хийж 4 төрлийн татварыг 10 хувиар тогтоож татварын өршөөл үзүүлэх хууль, “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих” тухай хуулийг үе шаттай хэрэгжүүлснээр албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй, хөрөнгө орлогын мэдүүлэгт тусгаагүй, хэмжээг нь бууруулсан, нуусан, далд байгаа аж ахуйн нэгж, хөрөнгө, орлого болон орлогоос бусад албан татвар ноогдох бараа, ажил, үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн, тайлагнасан, бүртгүүлсэн нөхцөлд нэг удаа албан татвар, хүү, торгууль ногдуулахгүйгээр холбогдох хариуцлагаас чөлөөлжээ. Ингэснээр татвар төлөгчдөд ижил гарааны нөхцөл бий болгон татварын шинэ системийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгосон. Энэхүү хууль хэрэгжүүлснээр 33,000 компанийн 34.2 их наяд төгрөгийн ажил үйлчилгээ ил болсноороо ач холбогдолтой

болж эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн (МУХАҮТ, МУИС-БС, 2017).

2. Зохицуулалтын үүрэг: Татварын хэмжээгээр дамжуулан эрэлтэд нөлөөлж, хөрөнгө салбараас салбарт шилжих замаар нөөцийн дахин хуваарилалт явагддаг. Өөрөөр хэлбэл зарим салбарыг дэмжих, зарим салбарын үйл ажиллагааг хумих арга хэмжээг татварын бодлогоор дамжуулан хэрэгжүүлдэг. Иймд зохицуулалтын, урамшууллын болон идэвхижүүлэлтийн дэд үүргүүдийг давхар гүйцэтгэнэ.

Монгол улсын татварын эрхзүйд энэхүү үүргийг биелүүлэхэд чиглэсэн зорицуулалтууд нилээдгүй байгааг төрөлжүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Нийгмийн хамгааллыг хэрэгжүүлэх чиглэлээр:

- 25-аас дээш ажилчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хараагүй ажилтан эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийн орлогыг,
- 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон тус тус татвараас чөлөөлнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно.

Санхүүгийн зах зээлийг дэмжих чиглэлээр:

- Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичгийн (бонд) хүүгийн орлогыг,
- Зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаасаа олсон орлогыг,
- Хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлогыг,
- Хөрөнгө оруулалтын сангийн орлогыг,
- Хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлсний орлогыг,
- Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлогыг тус тус чөлөөлнө.

Тодорхой салбарын үйл ажиллагаа болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр:

- Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлого,
- Гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого,
- Монгол Улсын нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаанаас олсон орлого,
- Улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого,
- Чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ,

цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлого,

- Чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг тус тус чөлөөнө.
- ХАА-н бүтээгдэхүүн (үр тариа төмс хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал)-ийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар,
- Жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, доор дурдсан салбарт үйл ажиллагаа явуулдаг албан татвар төлөгчийн ХАА, хөнгөн, хүнс, барилгын материал үйлдвэрлэлийн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар тус тус хөнгөлнө

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор:

- Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогыг

чөлөөлнө.

- Тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогод ногдох албан татварыг тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээгээр хөнгөлнө

Бүх нийтийн эрүүл мэнд, спортын боловсролыг дэмжих чиглэлээр:

- Стандартыг хангасан спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогыг хөнгөлнө.

Бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

- Аймаг, сумын төв нь нийслэл (Улаанбаатар) хотоос 550 км-ээс хол байршилтай аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгож (нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан) байгаа татвар төлөгчийн татвар ногдох орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө.

Үүний зэрэгцээ зарим зардлуудын татвар ноогдох орлогоос хасагдах дээд хязгаарыг тогтоох, орон нутагт ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, согтууруулах ундаа худалдах, импортлох, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх,

импортлох, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх, автобензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох, ярианы үйлчилгээ эрхлэх, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, түгээх, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх, авто зам, замын байгууламжийг барих, засварлах, цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж орлого олж байгаа аж ахуйн нэгжийн энэ үйл ажиллагаатай холбоотой орлогыг татвараас чөлөөлөхгүй байх (12 дугаар заалт) зэрэг зохицуулалтыг хийдэг. Түүнчлэн татварын тайлангаар тодорхойлсон алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хуулийн заалт ч (Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйл) үйлчилж байна. Эдгээр нь зохицуулах үүргийн үл зохицуулах дэд үүрэгт хамаарах юм.

Эдгээрт үндэслэн монгол улсын татварын тогтолцоо эрхзүйн орчинд зохицуулалтын үүргүүд урамшуулах болон үл урамшуулах, идэвхижүүлэх болон үл идэвхижүүлэх үүргийг биелүүлж ирсэн байгаа ч эдгээрийн үр нөлөөг үнэлсэн болон үнэлэх тухай зохицуулалт хомс байна.

3. Хяналтын үүрэг: Татварын үр ашгийг үнэлж цаашид санхүүгийн нөөцийн хэрэгцээ, татварын орлогын хэмжээг жишин үзэж, татварын систем болон төсвийн бодлогыг шинэчлэн өөрчлөх замаар хэрэгждэг.

Хүснэгт 4-өөс татварын орлого нь санхүүгийн үүргийг хангалттай биелүүлж төсвийн орлого бүрдүүлсээр байгаа боловч зарлага нь орлогын өсөлтөөс илүү хурдтай өсөж байгаа нь жил тус бүрийн алдагдал өсөж байгаагаас харагдаж байна. Үүнээс

Хүснэгт 4. Төсвийн ашиг, алдагдал (их наяд төгрөгөөр)

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Төсвийн орлого	1.9	1.8	1.8	2.7	4.2	4.9	5.9	6.3	6.0	6.0
Төсвийн зарлага	1.7	2.5	2.3	3.1	5.0	6.0	6.2	7.0	7.1	9.5
Ашиг (алдагдал)	0.2	(0.7)	(0.5)	(0.4)	(0.8)	(1.1)	(0.3)	(0.7)	(1.1)	(3.5)

Эх сурвалж: 1212.mn

гадна төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг үнэлэх, үр дүнгээр нь санхүүгийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, цаашдын бодлого боловсруулахдаа авч үзэх тогтсон систем байхгүй байгаа нь татварын орлогын үр ашигтай зарцуулалт, татварын болон төсвийн бодлогын шинэчлэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг биелүүлдэг гэж үзэх үндэсгүй гэж харагдаж байна.

4. Нийгмийн үүрэг: Ялгаатай татвар ногдуулах замаар хэрэгждэг. Энэхүү үүрэг нь хүн амын амьжиргааг тэнцвэржүүлэх үүрэгтэй.

Монгол улсын хуулинд татварын тэгш шударга байх зарчмын шалгуур болох нийгмийн баялагаас хүртсэн хэмжээгээр нийгмийн зардлыг санхүүжүүлэхэд хувь нэмрээ оруулах татварын ачаалал иргэн бүрт ижил байх нөхцөлийг хангаж аж ахуйн нэгж, байгууллага орлогоос хамаарсан шатлалтайгаар татвар төлөх, хувь хүмүүс орлогоос хамааран ялгаатай хөнгөлөлт эдлэх боломжтойгоор тусгасан байна.

Их орлогод их татвар, бага орлогод бага татвар ногдуулдаг, хөдөлмөр эрхлэх чадвараа 50-иас илүү хувиар алдсан иргэн ажиллуулж байгаа аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх тухай заалт (19.8), хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагад хандив өгсөн бол татвар ногдох орлогоос хасаж тооцох тухай заалт (19.10) гэх мэт байгаа ч энэ үүргийн биелэлтийг дам боловч иргэдийн амьжиргааны түвшин, хүний

хөгжлийн үзүүлэлтүүдээр хэмждэг нь тогтсон практик ажээ. Сүүлийн 5 удаагийн үзлэгийн дунджаар ядуурлын түвшин 30 орчим хувьтай, 2017 оны статистикийн мэдээгээр амьжиргааны баталгаажих доод түвшин 198.6 мянган төгрөг, дундаж цалин 1,038.9 мянган төгрөг байгаа нь манай татварын систем иргэдийн амьжиргааг тэнцвэржүүлдэг гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар орчин үеийн татварзүй үндсэн дөрвөн чиглэлийн үүргийг хүлээдэг болохыг тодорхойлон, Монгол улсын татварын тогтолцоо эдгээр үүргүүдийг хэрхэн биелүүлж байгааг судалж санхүүгийн болон зохицуулалтын үүргүүдийг тодорхой түвшинд биелүүлж байгаа боловч төсвийн зарлагын үр ашгийг үнэлж зохицуулалт хийх, төсөвт төвлөрсөн орлогоор түүнийг бүрдүүлэгч татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалсан, нийгэмд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй байна гэж үзлээ. 2017 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) болон Бизнесийн сургуулийн багш нарын судалгааны багийн хийсэн санал асуулгын үр дүн ч үүнийг баталж байна (МҮХАҮТ, МУИС-ийн БС, 2017).

Бид татварын тогтолцооны шинэчлэлийг хийхдээ татварын эдгээр үүргүүдийг харилцан уялдаатайгаар биелүүлдэг тийм тогтолцоотой болох тал руу чиглүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Ашигласан материал

1. Fiore, F. D., Pedro, T. (2002). The Optimal Mix of Taxes on Money, Consumption and Income, *European Central Bank, Working Paper Series*, 135
2. Kaplow, L. (2010). *The Theory of Taxation and Public Economics*, Princeton University Press, Princeton and Oxford
3. Kharitonenko, K. A. (2008). Tax Functions in the System of the National Economy Modern Innovative Development, *Vestnik Samara State University of Economics*, 7 (45), 109-114
4. Polinsky, M., Shavell, S. (2007). *Taxation: Handbook of Law and Economics*, Vol. 1, Elsevier
5. Овчинников, В. Н., Клюкович, З. А. (2012). Налоги и налогообложение: Развитие теории налогов как отражение эволюции систем налогообложения, *Вестник Адыгейского государственного университета - Серия 5: Экономика*
6. Понемасов, А. Д. (2014). Налоговая система Российской Федерации: Пути совершенствования, *Вестник Омского университета - Серия 1: Экономика*, 168-172
7. Попова, Л., Коростелькина, И., и др. (2017). *Теория налогообложения*, Кнорус, Москва, 2017
8. МҮХАҮТ, МУИС-БС (2017). *Монгол Улсын татварын тогтолцооны шинэчлэл, татварын оновчлол*, Улаанбаатар
9. МҮХАҮТ, МУИС-ийн БС (2017). *Бизнесийн орчны судалгаа*
10. 1212.mn, Үндэсний статистикийн хороо